



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/23

Баян-Овоо

**Авто машиныг данс бүртгэлээс  
хасаж актлах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах шилжүүлэх журам”, 2022 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 5.11 дахь заалт, Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний 5-р хуралдааны 11 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2025 оны А/227 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Орон Нутгийн Өмчийн Газрын 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 107 тоот албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу авто тээврийн дансанд бүртгэлтэй 86-02 ХЭҮ улсын дугаартай Nissan Patrol маркийн 40,000,000 (Дөчин сая) төгрөгийн балансын үнэтэй, 13,749,999,79 (Арван гурван сая долоон зуун дөчин есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг далан есөн мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг данснаас хасч актлахыг нягтлан бодогч (Д.Энхзул), нярав (Д.Гэрэлтуяа) нарт үүрэг болгосугай.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлд хяналт тавьж, холбогдох тайлан мэдээг танилцуулахыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (М.Ариунгэрэл)-д даалгасугай.

ДАРГА

Д.ГЭРЭЛМАА



020000112